



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Нэр дэвшүүлж, санал болгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 41 дүгээр тушаалаар байгуулагдсан шалгалтын комиссын саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын Төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах референтийн албан тушаалд Барын Уранчимэг, Хорооны хуралдааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалд Эрдэнийн Өлзийсайхан, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Хянан шалгагч (банк бус санхүүгийн байгууллага)-ийн албан тушаалд Жаргалын Отгонбаатар, Хянан шалгагч (мөнгө угаахтай тэмцэх алба)-ийн албан тушаалд Амартүвшингийн Уянга, мэргэжилтний албан тушаалд Гантөмөрийн Нямцэцэг, Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэл зохицуулалтын газрын Хянан шалгагч (хяналт шалгалтын чиглэл)-ийн албан тушаалд Нямын Лхагважав, Бодлого зохицуулалт, бүртгэл зөвшөөрлийн чиглэлийн мэргэжилтний албан тушаалд Баатарцогтын Арьяаманал, Банк бус санхүүгийн байгууллагын газрын мэргэжилтэн (бүртгэл, зөвшөөрлийн чиглэл)-ий албан тушаалд Дарамринчингийн Хулан, Үнэт цаасны газрын мэргэжилтэн (бүртгэл, зөвшөөрлийн чиглэл)-ий албан тушаалд Баасангийн Цацралтуяа, мэргэжилтэн (бодлого зохицуулалтын чиглэл)-ий албан тушаалд Энхболдын Ундралсайхан нарыг тус тус томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Б.Уранчимэг, Ж.Отгонбаатар, А.Уянга, Н.Лхагважав, Э.Өлзийсайхан, Д.Хулан, Б.Арьяаманал, Г.Нямцэцэг, Б.Цацралтуяа, Э.Ундралсайхан нарыг тус тусын албан тушаалд томилохыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга (Т.Жамбаажамц)-д санал болгосугай.

ДАРГА



Л.ЦЭДЭВСҮРЭН

24000137